



2017 оны 11 дүгээр сарын 22  
№43/1000/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



**Монгол Улсын  
хууль**

**Биеийн тамир, спортын тухай**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

540.	Биеийн тамир, спортын тухай		2074
541.	Биеийн тамир, спортын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай		2090
542.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай		2090
543.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай		2091
544.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай		2091

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

545.	Хуулийн төслүүдийг буцаах тухай	Дугаар 53	2092
------	---------------------------------	-----------	------

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

546.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 50	2093
547.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 51	2093

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

548.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 290	2094
------	-----------------------------	------------	------

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

549.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 06	2102
------	---	-----------	------



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх зүйн үндсийг тодорхойлж, биеийн тамир, спортыг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Биеийн тамир, спортын хууль тогтоомж

2.1.Биеийн тамир, спортын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Үндэсний их баяр наадмын тухай<sup>2</sup> хуулиар зохицуулаагүй үндэсний спорттой холбоотой бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Төрийн бус байгууллагын тухай<sup>3</sup> хуулиар зохицуулаагүй спортын холбооны спортын үйл ажиллагаатай холбоотой бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

#### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Үндэсний их баяр наадмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Төрийн бус байгууллагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1997 оны 03 дугаарт нийтлэгдсэн.



4.1.1. “идэвхтэй хөдөлгөөн” гэж хүний булчингийн үйл ажиллагааны тусламжтайгаар 10 ба түүнээс дээш минутын хугацаанд тасралтгүй хүч зарцуулан тогтмол хийж байгаа хөдөлгөөнийг;

4.1.2. “биеийн тамир” гэж хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.3. “спорт” гэж хүний оюун ухааны болон бие бялдрын хөгжлийг дэмжсэн идэвхтэй үйлдлийг;

4.1.4. “бие бялдрын боловсрол” гэж боловсролын албан болон албан бус хэлбэрээр идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх арга барил, мэдлэг, дадал эзэмшүүлэх үйл ажиллагааг;

4.1.5. “үндэсний спорт” гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний онцлог шинжийг агуулсан спортыг;

4.1.6. “спортын тэмцээн” гэж тогтоосон дүрмийн дагуу өрсөлдөх үйл явцыг;

4.1.7. “спортын наадам” гэж нэгдсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа спортын тэмцээн, соёл урлагийн арга хэмжээний нэгдлийг;

4.1.8. “тамирчин” гэж спортын сургалт-дасгалжуулалтаар бэлтгэгдэн, спортын тэмцээнд оролцдог этгээдийг;

4.1.9. “дасгалжуулагч” гэж сургалт-дасгалжуулалт, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагааг удирдаж байгаа этгээдийг;

4.1.10. “биеийн тамирын арга зүйч” гэж биеийн тамир, спортын нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахад болон иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх этгээдийг;

4.1.11. “спортын холбоо” гэж нэг, эсхүл хэд хэдэн спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг;

4.1.12. “спортын клуб” гэж идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх, сургалт-дасгалжуулалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

4.1.13. “спортын барилга байгууламж” гэж спортоор хичээллэх, спортын тэмцээн зохион байгуулах зориулалт бүхий байгууламж, түүний дэд бүтцийг;



4.1.14. “допинг” гэж спортын үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглосон бодис, хориотой аргыг;

4.1.15. “Олон улсын допингийн эсрэг агентлаг” гэж допингийн эсрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хянах чиг үүрэг бүхий олон улсын байгууллагыг.

## **5 дугаар зүйл. Биеийн тамир, спортын үндсэн зарчим**

5.1. Биеийн тамир, спортод дараахь үндсэн зарчмыг баримтална:

5.1.1. идэвхтэй хөдөлгөөн, спорт нь бүх нийтэд хүртээмжтэй, тогтвортой байх;

5.1.2. хувь хүний онцлог, бие бялдрын хөгжилд нийцсэн олон хувилбартай, сонголт хийх боломжтой байх;

5.1.3. төр, хуулийн этгээд, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах;

5.1.4. спортыг ялгаварлан гадуурхалт, шударга бус өрсөлдөөнөөс ангид байлгах.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

### **6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

6.1. Засгийн газар нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. биеийн тамир, спортын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

6.1.2. биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;

6.1.3. иргэний нас, хүйс, хэрэгцээ сонирхолд нийцсэн биеийн тамир, спортын төрлийг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтот хөтөлбөр батлах;



6.1.4.үндэсний спорт, багийн спортын төрлийг хөгжүүлэх хөтөлбөр батлах;

6.1.5.улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах талаар шийдвэрлэх, зохион байгуулалтын журам батлах;

6.1.6.Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам батлах.

## **7 дугаар зүйл.Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

7.1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.биеийн тамир, спортын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, хяналт тавих;

7.1.2.эдийн засгийн тооцоо, материаллаг бааз, хүний нөөцийн судалгаан дээр үндэслэн нутаг дэвсгэртээ улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах талаар нэр дэвших эрх авах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэх;

7.1.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог дэмжих.

## **8 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

8.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.харьяа нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

8.1.2.харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх;

8.1.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх;



8.1.4.суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах;

8.1.5.биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах;

8.1.6.хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бий болгох, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх;

8.1.7.биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах;

8.1.8.аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлөх.

## **9 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

9.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.биеийн тамир, спортын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

9.1.2.биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, холбогдох бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтын ажиллагааг уялдуулах;

9.1.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах;

9.1.4.энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэх;

9.1.5.тухайн жилд Монгол Улсад зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтыг батлах;

9.1.6.энэ хуулийн 6.1.4, 6.1.5, 10.1.3-д заасан тэмцээн, наадмыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

9.1.7.биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам батлах;

9.1.8.улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмыг батлах.

9.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1.бие бялдрын боловсролыг дэмжих, бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын хичээлийн сургалтын агуулга, стандарт, хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг тогтооходоо биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тусгах;

9.2.2.бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь сургалтын агуулга, стандарт, хичээлээс гадуурх сургалтын ажлын хөтөлбөрийг зөрчин суралцагчдад биеийн тамир, спортын заал, талбай, хэрэглэл, тоног төхөөрөмжийг төлбөртэй ашиглуулахыг хориглох;

9.2.3.боловсролын сургалтын байгууллага, суралцагчдын сургуулийн орчинд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үндэсний стандартад нийцсэн биеийн тамир, спортын заал, талбай, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

9.3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1.хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг идэвхтэй хөдөлгөөн, спортоор дамжуулан зохион байгуулах;

9.4.Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.4.1.Эрүүл мэндийн даатгалын тухай<sup>4</sup> хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтад хамрагдах магадлан итгэмжлэгдсэн спортын клубийн нэрсийг хүргүүлэх.

<sup>4</sup>Эрүүл мэндийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 08 дугаарт нийтлэгдсэн.





## **10 дугаар зүйл.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

10.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, биеийн тамир, спортын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.2.бие бялдрын түвшин тогтоох стандартыг боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай<sup>5</sup> хуулийн 6.5-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх;

10.1.3.улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах спортын холбоог сонгон шалгаруулах;

10.1.4.биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх;

10.1.5.хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх ажлыг зохион байгуулах;

10.1.6.улсын хэмжээнд зохион байгуулах спортын наадмын хөтөлбөрт багтах спортын төрлийг тогтоох, тэмцээний зохион байгуулалтыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;

10.1.7.бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

10.1.8.допингийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

10.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖ ДЭХ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

## **11 дүгээр зүйл.Спортын холбооны чиг үүрэг**

11.1.Спортын холбоо нь тухайн спортын төрлийг дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, төлөөлөгчийн газар, салбар, спортын

<sup>5</sup>Стандарчилал, тохирлын үнэлгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

клубээр дамжуулан иргэнд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.

11.2.Спортын холбоо нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тухайн спортын төрлийн олон улсын холбооны дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

11.3.Спортын холбоо нь дараахь эрх, үүрэгтэй байна:

11.3.1.спортын тэмцээний дүрэм, заавар, тухайн жилийн спортын тэмцээний хуваарь батлах;

11.3.2.улсын хэмжээний спортын тэмцээний нэгдсэн хуваарьт оруулах тэмцээний саналаа хүргүүлэх;

11.3.3.спортын тухайн төрлөөр олон улсын болон улс, бүсийн чанартай тэмцээн зохион байгуулах;

11.3.4.дасгалжуулагч, спортын шүүгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, олон улсын дүрмийн дагуу тухайн спортын төрлөөр дасгалжуулагч, спортын шүүгчээр ажиллах эрхийг хязгаарлах, хасах;

11.3.5.спортын тэмцээн, наадмын үед олон улсын дүрмийн дагуу тоглолтын үр дүнд нөлөөлөхүйц үйлдэл, эс үйлдэл гаргасан тамирчин, дасгалжуулагч, спортын шүүгчийн тухайн спортын тэмцээн, наадмын үйл ажиллагаанд оролцох эрхийг хязгаарлах, хасах;

11.3.6.олон улсын холбооноос гаргасан тэмцээний болон шүүлтийн дүрмийг мөрдүүлэх, тамирчны ёс зүйн дүрмийг олон улсын дүрэмд нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

11.3.7.тамирчны сургалт-дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, шигшээ баг бүрдүүлэн спортын тэмцээн, наадамд оролцуулах;

11.3.8.холбооны бүтэц, үйл ажиллагаа, зохион байгуулсан спортын тэмцээн, наадам, тамирчны амжилт, спортын цол, зэрэг, гишүүнчлэлээр мэдээллийн цахим сантай байх;

11.3.9.тамирчин, дасгалжуулагч, спортын шүүгчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

## **12 дугаар зүйл. Спортын клубийн үйл ажиллагаа**

12.1. Спортын клуб нь спортын тухайлсан болон хэд хэдэн төрлөөр үйл ажиллагаа явуулж болно.

12.2. Спортын клуб нь спортын төрлийн дагнасан сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд тухайн спортын төрлийн үндэсний стандартыг, үндэсний стандарт байхгүй тохиолдолд олон улсын спортын холбооноос гаргасан сургалт-дасгалжуулалтын хөтөлбөрийг мөрдөнө.

12.3. Сургалт дасгалжуулалтын үйл ажиллагааг удирдах, хянах зорилгоор дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч ажиллуулж, хичээллэгчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулна.

## **13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагаа**

13.1. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага нь биеийн тамир, спортын чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

13.1.1. ажлын байрны онцлог нөхцөлтэй уялдуулан ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх;

13.1.2. ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх төлөвлөгөө гарган ажиллах, спортын тэмцээн зохион байгуулах;

13.1.3. байгууллагын нийт төсвөөс ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхэд зарцуулах;

13.1.4. ажиллагсдын бие бялдрын түвшин тогтоох, байгаа түвшингээс бууруулахгүй байх, ахиулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

13.1.5. сайн дурын үндсэн дээр биеийн тамирын арга зүйч ажиллуулах.

13.2. Амралтын газар, хүүхдийн зуслан нь амрагчдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын үйл ажиллагаа явуулах орчин бүрдүүлнэ.

#### **14 дүгээр зүйл.Зэвсэгт хүчин, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагаа**

14.1.Зэвсэгт хүчин, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага нь энэ хуулийн 13.1-д зааснаас гадна дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

14.1.1.спорт нь мэргэжлийн тусгай бэлтгэлийг хангах үйл ажиллагааны салшгүй хэсэг байх, бие бүрэлдэхүүний мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх;

14.1.2.өөрийн үйл ажиллагааны чиглэлээр спортын тэмцээн, наадам зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

14.1.3.бие бүрэлдэхүүний бие бялдрын хөгжлийн тусгай норм, норматив тогтоох, тусгай сургалтын хөтөлбөр батлан мөрдүүлэх;

14.1.4.бие бүрэлдэхүүний бие бялдрын хөгжлийг хангах, спортоор хичээллэх, мэргэжлийн тусгай бэлтгэлийг хангах чиглэлээр спортын дагнасан нэгж ажиллуулах.

#### **15 дугаар зүйл.Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа**

15.1.Магадлан итгэмжлэл нь спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанарт хараат бус үнэлгээ хийж, мэргэжлийн дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм.

15.2.Спортын клуб нь сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлнэ.

15.3.Спортын клубийг магадлан итгэмжлэх журам, шалгуур үзүүлэлт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг биеийн тамир, спортын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **16 дугаар зүйл.Сургалт-дасгалжуулалтыг удирдан зохион байгуулах**

16.1.Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн спортын сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд



оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.2.Биеийн тамир, спортын боловсрол олгох их, дээд сургуулийг дасгалжуулагчийн мэргэжлээр төгссөн этгээд нь насанд хүрэгчдийн, залуучуудын үндэсний шигшээ багаас бусад шигшээ баг болон спортын клубт хичээллэж буй тамирчны сургалт-дасгалжуулалт, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагааг эрх авахгүйгээр удирдаж болно.

16.3.Биеийн тамир, спортын боловсрол олгох их, дээд сургуулийг дасгалжуулагчийн мэргэжлээр төгсөөгүй иргэн спортын сургалт-дасгалжуулалтыг энэ хуулийн 16.1-т заасан журмын дагуу эрх авсны үндсэн дээр эрхэлнэ.

### **17 дугаар зүйл. Спортын тэмцээн, наадмын зохион байгуулалт**

17.1.Улсын хэмжээний спортын тэмцээн, наадмыг спортын төрлийн онцлогоос хамаарч сум, дүүрэг, аймаг, нийслэл, бүс, улсын гэсэн шат дараалалтайгаар зохион байгуулж болно.

17.2.Улсын хэмжээний спортын наадмыг Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадмын мөчлөгт нийцүүлэн зохион байгуулна.

17.3.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараа онд зохиогдох улсын хэмжээний спортын тэмцээний нэгдсэн хуваарийг 09 дүгээр сарын 30-наас өмнө албан ёсоор зарлах бөгөөд улсын хэмжээний спортын тэмцээний нэгдсэн хуваарийг гаргахдаа спортын холбооны саналыг авсан байна.

17.4.Орон нутгийн чанартай спортын тэмцээн зохион байгуулах тохиолдолд зохион байгуулагч нь тухайн сумын биеийн тамирын арга зүйч, дүүргийн Биеийн тамир, спортын газарт ажлын 10 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд сумын биеийн тамирын арга зүйч, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар, тухайн спортын төрлийн холбоонд мэдэгдэнэ.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасны дагуу тухайн спортын холбоо нь спортын тэмцээн зохион байгуулах дүрэм, стандартын талаар тухайн орон нутаг дахь салбар, эсхүл биеийн тамирын арга зүйчээр дамжуулан танилцуулж, хяналт тавина.

17.6.Энэ хуулийн 17.3-т заасан хуваарьт ороогүй улсын хэмжээний спортын тэмцээн, энэ хуулийн 17.4-т зааснаар урьдчилан мэдэгдээгүй орон нутгийн чанартай спортын тэмцээн зохион байгуулахыг хориглоно.

## **18 дугаар зүйл. Үндэсний шигшээ баг**

18.1. Үндэсний шигшээ баг нь өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн гэсэн ангилалтай байна.

18.2. Монгол Улсыг төлөөлөн Олимп, Паралимпийн наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг зохион байгуулалтаар хангах Үндэсний хороог Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна.

18.3. Монгол Улсын нэрийн өмнөөс олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадамд оролцох үндэсний шигшээ багийг спортын холбоо бүрдүүлж, үйл ажиллагааг нь хариуцан зохион байгуулна.

18.4. Энэ хуулийн 9.1.8-д заасан журмын дагуу сонгосон спортын төрлийн спортын холбоонд гэрээний дагуу улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь спортын холбоотой Захиргааны ерөнхий хууль<sup>6</sup>, холбогдох журмын дагуу гэрээ байгуулж, санхүүжүүлнэ.

18.5. Аймаг, дүүргийн Засаг дарга нь аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь спортын 8-аас доошгүй төрлөөр спортын холбооны орон нутаг дахь салбартай хамтран сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь зохион байгуулна.

18.6. Оюутны дэлхийн аварга, Универсиадад Монгол Улсыг төлөөлөн оролцох шигшээ багийг залуучуудын шигшээ багаас бүрдүүлнэ.

## **19 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний биеийн тамир, спортын үйл ажиллагаа**

19.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын тэмцээн, наадамд оролцоход төрийн байгууллага, спортын холбоод дэмжлэг үзүүлж ажиллана.

19.2. Спортын тэмцээн, наадам нь хөгжлийн бэрхшээлтэй тамирчныг бие эрхтэн, хөгжлийн онцлогийн адил түвшинд нь өрсөлдүүлэх зарчмыг баримтална.

19.3. Энэ хуулийн 19.2-д заасан зарчмыг хангах зорилгоор улсын хэмжээний спортын тэмцээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчны ангиллыг олон улсын дүрмийн дагуу тогтоох комиссын бүрэлдэхүүн,

<sup>6</sup>Захиргааны ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



ажиллах журмыг биеийн тамир, спорт, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

## **20 дугаар зүйл.Тамирчны эрх, үүрэг**

20.1.Тамирчин нь доор дурдсан эрх эдэлнэ:

20.1.1.спортын төрлөө сонгох, хичээллэх;  
20.1.2.спортын тэмцээн, наадамд оролцох;  
20.1.3.спортын цол, зэрэг авах;  
20.1.4.харьяалагддаг спортын клубээс гэрээний дагуу өөр спортын клубт шилжих;

20.1.5.спортын тэмцээнд бэлтгэх, оролцох хугацаанд үндсэн ажил, сургуулиас чөлөөлөгдөх;

20.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.

20.2.Тамирчин нь доор дурдсан үүрэг хүлээнэ:

20.2.1.тамирчны ёс зүйн дүрэм, оролцож буй тэмцээний дүрэм болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

20.2.2.шударга өрсөлдөөнийг эрхэмлэх, допинг хэрэглэхгүй байх;

20.2.3.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

20.3.Тамирчин нь доор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

20.3.1.тамирчин Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадам, болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртвэл энэ хуулийн 6.1.6-д заасан мөнгөн шагнал авах;

20.3.2.харьяалах байгууллагаас цалин хөлс, урамшуулал авах.

## **21 дүгээр зүйл.Допингийн эсрэг үйл ажиллагаа**

21.1.Тамирчин нь Олон улсын допингийн эсрэг агентлагаас баталсан допингийн хориглосон жагсаалтад багтсан бодис, аргыг хэрэглэхийг хориглоно.

21.2.Дасгалжуулагч, багийн эмч нь тамирчинд допинг хэрэглүүлэхийг хориглоно.



21.3.Допингийн эсрэг үндэсний дүрмийг Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

21.4.Допингийн эсрэг үндэсний дүрмийн дагуу хэрэгжүүлэх ажлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

21.5.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, спортын холбоо бусад төрийн болон төрийн бус байгууллага нь хориглосон жагсаалтад багтсан бодис, аргууд, допингийн хор холбогдлын сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

## **22 дугаар зүйл. Спортын цол, зэрэг**

22.1.Спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тамирчинд олгох олон улсын хэмжээний мастер, спортын мастер, дэд мастер цол, спортын шүүгчид олгох улсын шүүгч цолны шалгуурыг тогтоож, олгоно.

22.2.Спортын цол авсан тамирчин, спортын шүүгчид харьяалах байгууллага нь мөнгөн урамшуулал болон цолны нэмэгдэл олгож болно.

22.3.Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй тамирчин, шүүгчид спортын цол олгоно.

22.4.Тамирчин, спортын шүүгчид спортын зэргийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх авсан спортын холбоо тогтоож, олгоно.

## **23 дугаар зүйл. Мэргэжлийн спорт**

23.1.Ашиг олох зорилгоор мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн тамирчны оролцоотой мэргэжлийн спортын тэмцээн зохион байгуулж болно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САНХҮҮЖИЛТ**

### **24 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын санхүүжилт**

24.1.Энэ хуулийн 6.1.4, 6.1.6 дахь заалт, 17.2, 18.4, 22.1, 26.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.





24.2.Энэ хуулийн 7.1.1, 8.1.3, 8.1.4 дэх заалт, 18.5, 26.6 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг орон нутгаас санхүүжүүлнэ.

### **25 дугаар зүйл.Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг**

25.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь спортын холбоо, спортын клуб, биеийн тамирын арга хэмжээ, спортын тэмцээн, наадмыг ивээн тэтгэж болно.

25.2.Аж ахуйн нэгж, байгууллагын спортын заал, талбай түүний дэд бүтцийг барих, спортын хэрэглэл, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд төрөөс татварын дэмжлэг үзүүлнэ.

25.3.Энэ хуулийн 25.2-т заасан татварын дэмжлэг үзүүлэх асуудлыг татварын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

### **26 дугаар зүйл.Биеийн тамир, спортын барилга байгууламж**

26.1.Спортын барилга байгууламж, заал, талбай нь стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

26.2.Спортын барилга байгууламж, заал, талбайн стандартыг боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

26.3.Биеийн тамир, спортын барилга байгууламж, заал, талбай нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байна.

26.4.Төрийн болон орон нутгийн өмчлөлийн спортын барилга байгууламж, заал, талбайн зориулалтыг өөрчлөхийг хориглоно. Хувьчлах болон тухайн барилга байгууламж, заал, талбайг буулгаж, шинээр барих тохиолдолд биеийн тамир, спортын зориулалтыг хэвээр хадгална.

26.5.Сургуулийн өмнөх, ерөнхий, дээд, мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллага нь суралцагчийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх стандартын шаардлага хангасан барилга байгууламж, заал, талбайтай байх нөхцөлийг бүрдүүлнэ.

26.6.Хувийн өмчийн хөрөнгө оруулалтаар баригдсан, стандартын шаардлага хангасан спортын барилга байгууламж, спортын зааланд иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж болно.

### **27 дугаар зүйл.Биеийн тамир, спортын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих**

27.1.Биеийн тамир, спортын хууль тогтоомжийн биелэлтэд бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажиллана.

27.2.Талууд гэрээнд маргааныг арбитраар шийдүүлэхээр харилцан тохиролцсон, шүүхийн харьяаллын бус бусад спортын үйл ажиллагаатай холбоотой маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлнэ.

### **28 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай<sup>7</sup> хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль<sup>8</sup>, эсхүл Зөрчлийн тухай<sup>9</sup> хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

29.1.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

29.2.Энэ хуулийн 8.1.4 дэх заалтыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

<sup>7</sup>Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup>Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

<sup>9</sup>Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

#### **1/12 дугаар зүйлийн 12.1.36 дахь заалт:**

“12.1.36.спортын холбоо, спортын клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжээс тухайн татварын жилд хандивласан 10 сая хүртэлх төгрөгтэй тэнцэх хэмжээний хандив, хөрөнгө.”

#### **2/18 дугаар зүйлийн 18.1.16 дахь заалт:**

“18.1.16.Биеийн тамир, спортын тухай хуулийн 26.2 дахь хэсэгт заасан стандартыг хангасан спортын барилга байгууламж, спортын заал, талбай, дэд бүтцийг барьж байгуулсан аж ахуйн нэгж тухайн спортын барилга байгууламж, спортын заал, талбайг ашиглаж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд ашиглалтын үйл ажиллагаанаас олсон 50 хувьтай тэнцэх хэмжээний орлого.”



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 07 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.19 дэх заалт нэмсүгэй:

“38.1.19.спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэл.”

**2 дугаар зүйл.**Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.18” гэсний дараа “, 38.1.19” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 07 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.12 дахь заалт нэмсүгэй:

“9.1.12.магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ.”



**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “байгууллага болон” гэсний дараа “магадлан итгэмжлэгдсэн спортын клуб,” гэж, мөн зүйлийн 3.1.7 дахь заалтын “хөнгөвчлөх болон” гэсний дараа “идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ,” гэж, 3.1.8 дахь заалтын “байгууллага болон” гэсний дараа “магадлан итгэмжлэгдсэн спортын клуб,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “шинжилгээнд хамруулах” гэсний дараа “, магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд урамшуулал олгох” гэж тус тус нэмсүгэй:

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

### Хуулийн төслүүдийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 11 дүгээр  
сарын 02-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мундагбаатарын Батсайханыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 11 дүгээр  
сарын 02-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бадамдоржийн Батхишигийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Равдангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 9 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 290

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Оюунхоролд даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 95 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ**

**Ж.ЭРДЭНЭБАТ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ**

**Д.ОЮУНХОРОЛ**

Засгийн газрын 2017 оны 290 дүгээр  
тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ДЭВШИЛТЭТ АРГА,  
ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛСЭН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ,  
БАЙГУУЛЛАГЫГ УРАМШУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой, аюултай нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж урамшуулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах, эрчим хүчийг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал болон дулаан алдагдлыг багасгах, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахад энэхүү журмыг баримтална.

1.3. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд урамшуулал олгоход энэхүү журам үйлчилнэ.

#### Хоёр. Урамшууллын хэлбэр

2.1. Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшуулал дараах хэлбэртэй байна:

2.1.1. байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Ногоон гэрчилгээ” олгоно;

2.1.2. байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээнд “Эко тэмдэг” олгоно.

2.2. Ногоон гэрчилгээ, Эко тэмдгийн гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### Гурав. Урамшууллын шалгуур үзүүлэлт

3.1. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад дараах чиглэлийг баримтална:

3.1.1. байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах;

3.1.2. агаар, орчны бохирдлыг бууруулах;

3.1.3. хүлэмжийн хийг бууруулах, эрчим хүч хэмнэх.

3.2. Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах чиглэлээр дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:





3.2.1. байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялагийг нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр даацад нь тохируулан зохистой ашигласан байх;

3.2.2. байгалийн баялгийг хаягдалгүй, иж бүрэн, хэмнэлттэй, үр ашигтай зохистой ашиглаж, дахин ашиглалтын түвшинг нэмэгдүүлсэн байх;

3.2.3. ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацийг нэвтрүүлсэн байх;

3.2.4. хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материалаар баригдсан, дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй, хаягдал ус цэвэрлэх технологи бүхий барилга байгууламжтай байх;

3.2.5. ойн сэргэн ургах чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, ашиглах, түүний төлөв байдлыг сайжруулах, хамгаалах дэвшилтэт арга, технологи нэвтрүүлж, модыг өргөн олдоцтой материалаар орлуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байх;

3.2.6. байгаль орчныг хамгаалж, доройтсон орчныг нөхөн сэргээх экосистемийн үйлчилгээг<sup>1</sup> тэтгэсэн байх;

3.2.7. цэнгэг усны хэрэглээг багасган хур тунадасны усыг хуримтлуулан үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан байх;

3.2.8. хаягдал бохир усыг цэвэрлэн эргүүлэн ашиглах замаар усны нөөцийг 50 хувиас дээш хэмнэж, дахин ашиглах боломж бүрдүүлсэн байх.

3.3. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

3.3.1. хөрсний үржил шимийг биологийн аргаар нэмэгдүүлсэн, химийн бохирдлыг бууруулсан байх;

<sup>1</sup>УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын 1.3.1-д тодорхойлсон.

3.3.2. хог хаягдлыг багасгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ангилан ялгах, дахин болон сэргээн ашиглах, устгах дэвшилтэт технологи нэвтрүүлсэн, хаягдал дахь хорт бодисын агууламжийг бууруулсан байх;

3.3.3. хог хаягдал ашиглан эрчим хүч, дулаан үйлдвэрлэсэн байх;

3.3.4. түлшний шаталтаас үүсэх хорт бодисын хэмжээг багасгасан байх;

3.3.5. авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг хийн болон цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх замаар тэдгээрийн ашиглалтын улмаас ялгарах хорт утааг бууруулсан байх.

3.4. Хүлэмжийн хийг бууруулах, эрчим хүчийг хэмнэх чиглэлээр дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

3.4.1. нүүрсхүчлийн хий болон хорт хийн ялгарлыг багасгах зорилгоор сэргээгдэх эрчим хүч ашигласан байх;

3.4.2. үйлдвэрлэл, үйлчилгээ болон нэгж талбайд ногдох эрчим хүчний хэрэглээг 20-иос доошгүй хувиар бууруулсан байх;

3.4.3. нар, салхи болон газрын гүний дулааныг ашиглах технологи, дулаалгын материал, халаах, хөргөх болон агааржуулах систем зэрэг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологи, тоног төхөөрөмж импортоор авсан, эсхүл үйлдвэрлэж зах зээлд тогтвортой нийлүүлсэн байх;

3.4.4. үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас агаар, орчинд ялгаруулах, бохирдуулах бодисын хэмжээг 50-иас доошгүй хувиар бууруулсан байх;

3.4.5. байгаль орчинд ээлтэй технологи зохион бүтээх, нэвтрүүлэх, нутагшуулах зэргээр технологийн шинэчлэл хийж, оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулсан байх.



3.5. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан, байгальд ээлтэй түүхий эд материал ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд олгох “Эко тэмдэг”-ийн шалгуур үзүүлэлт болон түүнийг үнэлэх аргачлалыг энэхүү журмын 5.3-т заасан Техникийн зөвлөл боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### Дөрөв. Урамшуулалд хамрагдах хүсэлт гаргах

4.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага урамшуулалд хамрагдах хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

4.2. Энэ журмын 4.1-д заасан хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

4.2.1. аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;

4.2.2. үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа нутаг дэвсгэрийн сум, дүүрэг, хорооны Засаг даргын, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны газрын тодорхойлолт;

4.2.3. итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, холбогдох мэргэжлийн байгууллагын тодорхойлолт, патент, ашигтай загварын гэрчилгээний хуулбар;

4.2.4. байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологийн тодорхойлолт, хүрсэн үр дүнгийн харьцуулсан үзүүлэлт, туршилтын тайлан;

4.2.5. эрх бүхий байгууллагаар хийлгэсэн байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

4.2.6. татварын өр төлбөргүй талаарх тодорхойлолт.

4.3. Энэ журмын 4.2-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзана.

## Тав. Комисс болон Техникийн зөвлөл, түүний бүрэлдэхүүн

5.1. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээний дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах комисс (цаашид “комисс” гэх)-ын бүрэлдэхүүн, ажлын удирдамжийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.2. Комиссын бүрэлдэхүүнд байгаль орчин болон бусад салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагын төлөөллийг оролцуулна.

5.3. “Эко тэмдэг”-ийн шалгуур үзүүлэлтийг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Техникийн зөвлөлийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна.

5.4. Техникийн зөвлөлийн бүрэлдэхүүнд мэргэжлийн хяналтын байгууллага, итгэмжлэгдсэн лаборатори, холбогдох эрдэм шинжилгээ болон судалгааны байгууллагын төлөөллийг оролцуулна.

5.5. Техникийн зөвлөл “Эко тэмдэг” олгох шалгуур үзүүлэлтийг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх дүгнэлтийг Комисст хүргүүлнэ.

5.6. “Ногоон гэрчилгээ” олгох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх аргачлалыг Комисс батална.

## Зургаа. Сонгон шалгаруулах ажиллагаа

6.1. Комисс нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн хүсэлт, холбогдох материалыг хянан үзэж, шалгуур үзүүлэлтийг хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүр сонгон шалгаруулна.

6.2. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Комисс байгаль орчны аудитын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.



6.3. Комисс нь шалгаруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон бүтээгдэхүүн, үйлчилгээг урамшуулалд хамруулах тухай санал, дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

6.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Комиссын санал, дүгнэлтийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” олгоно.

6.5. “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” олгосон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг байгаль орчны мэдээллийн санд бүртгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсаар мэдээлнэ.

#### Долоо. “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” ашиглах

7.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг”-ийн загварыг бүтээгдэхүүн, үйлчилгээний хаяг, шошго, сав, баглаа боодол болон ном, сэтгүүл, танилцуулга, сурталчилгаанд ашиглаж болно.

7.2. Комисс болон Техникийн зөвлөл нь “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 3 жил тутамд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

7.3. Энэ журмын 7.2-т заасан дүгнэлтээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” урамшууллын шалгуур үзүүлэлт буурсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн байгууллагад олгосон “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг”-ийг хүчингүй болгоно.

#### Найм. Дэмжлэг үзүүлэх

8.1. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлж, “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь урамшуулал, дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна:

8.1.1. байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, дотоодын болон олон улсын үзэсгэлэнд оролцуулах;



8.1.2. байгаль орчны үндэсний болон олон улсын шагналд нэр дэвшүүлэх;

8.1.3. ногоон зээлийн сангийн болон дотоод, гадаадын бусад хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтад хамруулах;

8.1.4. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хуульд заасны дагуу давуу эрхтэйгээр оролцуулах;

8.1.5. олон улсын ижил төстэй дэвшилтэт технологи бүхий байгууллагуудтай хамтран ажиллахад зуучлах;

8.1.6. үндэсний стандарт боловсруулах болон олон улсын стандартыг үндэсний стандарт болгоход мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

8.1.7. байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалтад хамруулах;

8.1.8. хуульд заасан бусад дэмжлэг.

#### Ес. Бусад зүйл

9.1. Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлнэ.

9.2. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахтай холбогдсон гомдлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

9.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг гомдлыг иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 11.50 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Д.Сугар /илтгэгч/, Н.Чинбат, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, мэдээлэл гаргагч иргэн Д.Батбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Д.Батбаатар Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд:***

“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн үндсэн зорилт нь “Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах дэг, журамтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” хэмээн тодорхойлсон байна. Гэтэл энэ хуулийн “Ерөнхий сайд,

Засгийн газрын гишүүдийг томилох асуудлыг хэлэлцэх журам” гэсэн 37 дугаар зүйлд “37.4. Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэсэн заалт оруулсан байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын бүрэн эрхийг хатуу тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад Улсын Их Хурал нь “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах; ...”, мөн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;” гэж маш тодорхой заасан байна.

Үндсэн хуулийн дээрх заалтуудад үндэслэн Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн хуулиудад тэдний бүрэн эрхийг нарийвчлан тогтоож өгсөн байдаг. Эдгээрээс харахад Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх, томилох эрх нь зөвхөн Улсын Их Хуралд байхаар зохицуулагджээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан онцгой ..., бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд 14 дүгээр зүйлийн 14.3.4 дэх заалтад Ерөнхий сайдыг томилохоор заасан бол Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг нөхөн томилохоор заажээ.

Харин Ерөнхий сайдыг томилох Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд түүнд нэр дэвшүүлэх асуудал нь улс төрийн нам, эвсэлд хадгалагдахаар хуульчлагдсан. Үндсэн хуулийн Гучин гуравдугаар





зүйлээр зохицуулагдсан харилцаанаас энэ нь тодорхой харагдах бөгөөд Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... Засгийн газар огцорсон, Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах буюу хүсэлтээр нь чөлөөлөх тухай шийдвэр гаргасан, Ерөнхий сайд нас нөгчсөн тохиолдолд Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам буюу намуудын сонгуулийн эвсэлээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч хүлээж авснаас хойш 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна." хэмээн баталгаажсан байна. Түүнчлэн, Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад Улсын Их Хуралд суудал бүхий нам Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх санал тавих эрхтэй гэж тус тус зохицуулжээ.

Эдгээр зохицуулалтаас харахад Монгол Улсын Ерөнхийлөгч нь бие дааж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрхгүй юм.

Гэтэл Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах дэг, журамтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийн "Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ." гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад "Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй

зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах,” гэснийг тус тус зөрчсөн байх тул хянан үзэж хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“... Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг ... Улсын Их Хуралд оруулах;” гэсэн энэхүү журмаар Ерөнхий сайдад нам, эвслээс нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч түүнийг томилох саналыг Улсын Их Хуралд оруулах үйл ажиллагааг хөндөөгүй бөгөөд Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь дэмжээгүй бол хэрхэн өөр хүний нэр дэвшүүлэхийг тодруулан зааж өгсөн зохицуулалт юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нэр дэвшүүлэх нөхцөл, журмыг хөндөөгүй ба өөр хүнийг нэр дэвшүүлэх саналыг оруулж ирэх хугацааг тодорхойлон зааж өгч, өмнө нь тогтоосон байсан хугацааг богиносгож, төрийн үйл ажиллагааны залгамж, чанарыг алдагдалгүй авч явах зэрэг нөхцөлийг бүрдүүлж, 7 хоногийн дотор нэр дэвшүүлэх хугацааг зааж өгсөн болно.

Мөн үйл ажиллагааны хувьд хэрэв олонхийн саналыг авахгүй бол хэрхэн зохицуулахыг тодорхойлон зааж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан Улсын Их Хуралд олонхи суудал авсан намын эрхэд халдаагүй заалт юм. Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-37.3 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад



заасны дагуу Ерөнхий сайдад томилох саналыг хэлэлцэхээр хуульчилсан байгаа нь олонхийн санал аваагүй тохиолдолд нөхөн нэр дэвшүүлсэн тохиолдолд мөн журмаар явах зохицуулалт юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн зарчмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг нэр дэвшүүлэх эрх бүхий нам, эвслийг тодорхойлсон болон санал оруулах эрх бүхий Ерөнхийлөгчийн эрхийг заасан Үндсэн хуулийн заалтыг зөрчилгүй, төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зохицуулалт хийж буй заалт байна.

Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг баримтлан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдаар томилуулах саналыг Улсын Их Хуралд оруулж, түүнийг нь холбогдох Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, хэрэв Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн саналыг нэр дэвшигч аваагүй бол тухайн томилуулах саналыг оруулж ирсэн Ерөнхийлөгч дахин өөр хүний нэрийг дэвшүүлэхээр энэхүү Ерөнхий сайдыг томилох үйл ажиллагаа эхэлсэн үе, шат дарааллаараа буцаж өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэхээр заасан. Энэ нь нөхөн нэр дэвшүүлэх ажиллагаанд анх нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд оруулсан ямар ч үе шатыг алгасахгүйгээр, ижил журмаар явагдахаар зохицуулагдаж байгаа ба Үндсэн хуулийн энэхүү заалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заавал давхардуулан заах шаардлагагүй учир Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалттай нийцэж байгаа болно.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус зөрчөөгүй байгааг анхааран үзэж шийдвэрлэхийг Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс хүсэж байна.” гэсэн байна.

### **ҮНДЭСЛЭЛ:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “санал оруулах” гэж томъёолсныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “нэр дэвшүүлнэ” гэсэн нь Үндсэн хуульд хэрэглэсэн нэр томъёоны агуулгыг өөрчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад зааснаар Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслээс Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх бөгөөд түүнийг томилох саналыг Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулах буюу уламжлах бүрэн эрхтэй байна. Гэтэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч бие даан өөр хүний нэр дэвшүүлэхээр томъёолсон нь Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгоогүй бүрэн эрхийг хуульчилжээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг нь Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрхийг Ерөнхийлөгчид олгосноороо Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв



хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;" гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Д.ОДБАЯР**

**ГИШҮҮД**

**Ш.ЦОГТОО**

**Д.СУГАР**

**Н.ЧИНБАТ**

**Д.СОЛОНГО**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2,25

**Индекс: 200003**